

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

Барилгын урсгал засварын материал
нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах тендерийн баримт
бичиг

Тендер шалгаруулалтын дугаар:

ХАН№19/48

Хаяг:

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ний конторын байр

Утас:

99020551

Факс:

70210167

ХАН№19/48 тоот тендерийн урилга

Барилгын урсгал засварын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр илгээж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn сайтаас /Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/ татаж үзнэ үү.

Хаяг :

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний
конторын байр 202 тоот өрөө

Утас: 99020551

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг цахимаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Санал болгож буй материалыг үнийн саналын маягтын дагуу ирүүлэх;
 - (б) Нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) ТООЗ 1.1 дэх заалтын дагуу бусад материалыг бэлтгэж ирүүлэх.
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар, НӨАТ биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх 4. 2017-2018 оны аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлэх 5. Сүүлийн нэг /2018 он/ жилийн борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/ 6. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхийн ямар нэгэн зарга маргааны талаарх тодорхойлолт. /Шүүхийн төрөлжсөн архив, Шийвдэр гүйцэтгэх албанаас тус тус ирүүлэх/ 7. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын тендерийн лавлагааг үндэслэнэ/ 8. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолтыг ирүүлэх /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх/ 9. Тендерт оролцогч нь ГТН 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 10. Нийлүүлэх хугацаа нь гэрээ байгуулсанаас хойш 25 хоногоос ихгүй, хүргэх газар Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн агуулахад 11. Одоо хэрэгжүүлж буй бараа материал нийлүүлж байгаа гэрээний жагсаалтыг маягтын дагуу ирүүлэх. 12. Сүүлийн 3 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт гэрээ, гэрээ дүгнэсэн акт тэдгээрийн ажлын өртөг, хугацаа байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлэх./2016-2018 онуудын аль нэгэнд/ 13. Бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон банкаас авах зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 80 %-иас багагүй байна. 14. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 16 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Нээлтийг 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 16 цаг 30 минутаас цахим системээр нээнэ.</p> <p>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99020551</p>
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна:</p> <p>ХАН№19/48 “Барилгын урсгал засварын материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг”</p> <p>Багцтай эсэх: Үгүй</p>

Гурав. БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

д/д	Материалын нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Будаг шингэлэгч	шилтэй	ш	140
2	Боронз /найруулсан /	найруулсан	кг	181
3	Будаг /хар/	Төмрийн будаг	кг	132
4	Будаг /шар/	Төмрийн будаг	кг	49.4
5	Будаг /улаан/	Төмрийн будаг	кг	68
6	Будаг /ногоон/	Төмрийн будаг	кг	66
7	Будаг /саарал/	Төмрийн будаг	кг	827
8	Будаг /Цагаан /	Төмрийн будаг	кг	41
9	өнхрүүш	10 см	ш	109
10	өнхрүүш	20 см	ш	70
11	Электрод	φ3	кг	312
12	Банз	2.5м*15см*5см	ш	50
13	Спирт /цэвэрлэгээнд/	техникийн	л	6.6
14	цемент		шуудай	5
15	Гэрэлтүүлгийн Ламп /мушгиа/	220В сүүн	ш	36
16	Розетка		ш	9
17	Булан төмөр	50*50*4	м	286
18	Булан төмөр	75*75*5	м	64
19	Полосо	өргөн нь 35 мм	м	212
20	Боолт	M17	ш	36
21	Круг	φ22	м	354
22	Труба	Ф-25	м	30
23	Тоолуурын шаариг		ш	2900
24	Тоолуурын лацны тугалга		ш	8200
25	Дельфинтэй цавуу		ш	20
26	Цавууны лаа	том	ш	50
27	Шил өнгөлөгч		ш	20
28	Тоолуурын лацны нүхтэй боолт	1.2см /урт/	ш	500
29	Тоолуурын лац ломбо		ш	1000
30	Өнгийн Лент		ш	454
31	Хар лент		ш	70
32	0 клем		ш	110
33	Шүршдэг будаг /хар саарал/		ш	35
34	Цүү	дундын	ш	380
35	Цоож	дундын	ш	880
36	Кодтой Цоож	дундын	ш	263
37	Арчих материал	Тос сайн шингээдэг материал	м	800
38	Тэлэгч болт 16		ш	20
39	Селикон цавуу		ш	33
40	Гэрэл суурийн хамт	LED-50W	ш	2
41	led гэрэл	220В 36Вт	ш	40
42	Патрон		ш	14
43	Катник	Ф6мм	кг	520.2
44	Зэв арилгагч		ш	30
45	Нугас	щитний	ш	259
46	Хадагч хадаас		хайрцаг	4
47	Цахилгаан халаагуур	Тень	ш	2
48	Дээвэр	5 ханатай гэрийн	ш	2

		/эсгийн/		
49	Туурга	5 ханатай гэрийн /эсгийн/	ш	4
50	Ажлын бээлий	цагаан таван хуруутай резингүй	ш	342.8
51	Ажлын бээлий	ажлын таван хурууны алга резинтэй	хос	264
52	PVC хуванцар хоолойны булан	оруулгын кабелины ф30	ш	134
53	PVC хуванцар хоолой	оруулгын кабелины ф30, 10 м урттай	ш	134
54	Труба	25мм2	м	30
55	Тасдагчны ир	жижиг	ш	111
56	Лист төмөр	2*1м*1мм	ш	60
57	цавуу	Шар цавуу	ш	17
58	Татлага	6 м урттай	ш	1
59	Трос	1.5 м урттай	ш	1
60	Труба	32	м	42
61	туузан төмөр	40*4мм	м	12
62	Угольник 40*40*4		м	298
63	Улайсах чийдэн 100В		ш	150
64	Хасах гэрэл		ш	15
65	Хомут /төмөр/ щит	М-120	хос	30
66	Хөрөөний ир	Төмрийн	ш	75
67	хумслагч / 2 дарагчтай /	Зажем-50мм	ш	60
68	Цоож / нэг түлхүүртэй /		ш	175
69	PVC хоолой 4м	ф100	м	60
70	Багс /жижиг/	3см	ш	188
71	Багс /дунд/	5см	ш	33
72	Багс/Том/	10см	ш	35
73	Боолт гайк	м-14	ком	13
74	Боолт гайк шайб М10*25	м-10	ш	75
75	Боолт гайк шайб М17*25	м-17	ш	60
76	Өрөм ф10		ш	30
77	Өрөм ф6		ш	30
78	Төмөр тор		м2	18
81	Суурин точилийн ир		ш	4
82	Төмрийн хөрөөний ир		Боодол	1
83	Супер цавуу		ш	2
84	Киперний лент		Боодол	2
85	Тос цэвэрлэх бодис РВ-1		л	10
86	Зүлгүүр		м	4
87	Прожектор		ком	1
88	Порпан		кг	30
89	Ширэмний электрод		Боодол	1
90	Автомат 250А		ш	3
91	Автомат 100А		ш	3
92	Гэрэл 50 Вт (LED) эрчим хүчний хэмжнэлтийн ажлын хүрээнд		ш	160
93	Конденсатор		ш	100
94	Бор дарлага		ш	300
95	АБ цавуу		ш	10
96	Лац, ломбо, дардас		ш	2
97	Батарей 9В		ш	14

98	Резин	50см өргөнтэй	М	24
99	Труба ф100		М	24
100	Труба ф50		М	12
101	ф50 хаалт		Ш	2

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны сарынөдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ажлын [санал болгож буй нийлүүлэх хугацааг бичнэ] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Техникийн тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|---|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Нийлүүлэхээр санал болгож буй бараа материалыг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо үйлдвэрийн хэсэг БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулахад |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 (нэг) жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор барагдуулна. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
 - 1.1 Нийлүүлэхээр санал болгож буй материалыг захиалагчийн томилсон ажлын хэсэг хүлээн авна.

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
 - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
 - 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;

3. Баталгаат засвар (ГЕН-5)
 - 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]

4. Төлбөр (ГЕН – 7)

Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний төлбөрийг гэрээ дүгнэсэн акт болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн **60** хоногийн дотор төлбөрийг барагдуулна.

.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
 - 9.1. Алданги оногдуулах хувь: **Нэг хоногийн 0,5%**
Алдангийн нийт дүн: **Гэрээний үнийн дүнгийн 10%**